

ГЕНЕТИК НӨӨЦИЙН ТУХАЙ ХУУЛЬ
НЭГДҮГЭЭР БҮЛЭГ
НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1 дүгээр зүйл. Хуулийн зорилт

1.1.Энэ хуулийн зорилт нь Монгол Улсын нутаг дэвсгэр дэх генетик нөөц, түүнтэй холбоотой уламжлалт мэдлэгийг судлах, бүртгэх, хадгалж хамгаалах, ашиглах, тэдгээрийг ашигласнаас үүдэх үр шим, ашгийг хүртээхтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

2 дугаар зүйл. Генетик нөөцийн тухай хууль тогтоомж

2.1.Генетик нөөцийн тухай хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль, Байгаль орчныг хамгаалах тухай хууль, Иргэний хууль, энэ хууль болон эдгээртэй нийцүүлэн гаргасан эрх зүйн бусад актаас бүрдэнэ.

3 дугаар зүйл.Хуулийн хамрах хүрээ

3.1.Энэ хуулиар мал, хөдөө аж ахуйн таримал ургамлаас бусад ургамал, амьтан, аливаа бичил биетнээс гаралтай генетик нөөц болон түүнтэй холбоотой уламжлалт мэдлэгийн харилцааг зохицуулна.

4 дүгээр зүйл.Хуулийн нэр томъёоны тодорхойлолт

4.1.Энэ хуульд хэрэглэсэн дараахь нэр томъёог доор дурдсан утгаар ойлгоно:

4.1.1."биологийн нөөц" гэж экосистемийн амьд бүрэлдэхүүн хэсгүүд, тэдгээрийн генетик нөөцийг;

4.1.2."биологийн судалгаа" гэж амьтан, ургамал, бичил биетний биологийн нөөцийг илрүүлэх, цуглуулах, боловсруулах үйл явцыг;

4.1.3."биохайгуул" гэж биологийн олон янз байдлын генетик нөөцийг арилжааны зорилгоор илрүүлэх, цуглуулах, боловсруулах үйл явцыг;

4.1.4."биотехнологи" гэж Биологийн олон янз байдлын тухай конвенцийн 2 дугаар зүйлд заасанчлан биологийн систем, амьд бие, түүнээс гаралтай бодисыг ашиглан тодорхой зориулалт бүхий бүтээгдэхүүн эсхүл арга ажиллагаа бий болгох аливаа технологийг;

4.1.5."бичил биетэн" гэж зөвхөн микроскопоор харах боломжтой нэг ба олон эст амьд бие, вирус;г;

4.1.6."ургамал" гэж Байгаль орчныг хамгаалах тухай 3.2.3-т заасныг;

4.1.7."амьтан" гэж Байгаль орчныг хамгаалах тухай 3.2.4-т заасныг;

4.1.8."генетик материал" гэж ургамал, амьтан, бичил биетний удамшлын мэдээлэл агуулсан молекулыг;

4.1.9."генетик нөөц" гэж ургамал, амьтан, бичил биетний бодит эсхүл боломжит ашиг, үнэ цэнэ бүхий генетик материал, биохимийн нэгдлийг;

4.1.10."генетик нөөц ашиглах" гэж генетик нөөцийн генийн болон биохимийн бүтцийг судлах, генетик нөөц, түүнтэй холбоотой уламжлалт мэдлэгийг ашгийн ба ашгийн бус зорилгоор илрүүлэх, цуглуулах, боловсруулах, бүтээгдэхүүн бий болгох үйл явцыг;

4.1.11.“генетик нөөцтэй холбоотой уламжлалт мэдлэг” гэж түүхэн хөгжлийн явцад бий болж өвлөгдөн уламжлагдаж ирсэн, генетик нөөцийн онцлог шинж чанар, түүнийг ашиглах арга ухаан, мэдлэг,ур чадварыг;

4.1.12.“ашиглах эрхийн зөвшөөрөл” гэж генетик нөөц, түүнтэй холбоотой уламжлалт мэдлэгийг илрүүлэх, биохайгуул хийх, судлах, тэдгээрийг ашиглах тусгай зөвшөөрлийг;

4.1.13.“генийн сан” гэж амьд бие, эрхтэн, эд, эс, удамшлын материалын сан хөмрөгийг;

4.1.14.“талуудын хэлцлийн гэрээ” гэж генетик нөөц, түүнтэй холбоотой уламжлалт мэдлэгийг ашиглах, тэдгээрийг ашигласнаас үүдэх үр шим, ашгийг хүртээх нөхцөлийг тодорхойлсон генетик нөөц эзэмшигч ба ашиглагчийн хооронд байгуулсан хэлцлийн баримт бичгийг;

4.1.15.“урьдчилсан мэдэгдэл” гэж генетик нөөцтэй холбоотой уламжлалт мэдлэгээ ашиглуулж болох талаар эзэмшигчээс өгсөн албан ёсны зөвшөөрлийг.

5 дугаар зүйл.Хуулийн зарчим

5.1.Генетик нөөц, түүнтэй холбоотой уламжлалт мэдлэгийг эзэмшигч, ашиглагчийн эрх ашгийг хамгаалах, нээлттэй, ил тод байх, генетик нөөц, түүнтэй холбоотой уламжлалт мэдлэгийг ашигласнаас үүдэх үр шим,ашгийг тэгш, шударгаар хуваах, хүртээх зарчим баримтална.

6 дугаар зүйл. Генетик нөөц, түүнтэй холбоотой уламжлалт мэдлэгийн өмчлөл, эзэмшил

6.1.Монгол Улсын Үндсэн хуулийн Зургадугаар зүйлийн 1, 2 дахь хэсэгт заасны дагуу генетик нөөц төрийн өмчлөлд байна.

6.2.Генетик нөөцтэй холбоотой тухайн уламжлалт мэдлэгийн эзэмшигчийг тогтоох боломжгүй тохиолдолд төр эзэмшигч болно.

6.3.Энэ хуульд заасан нөхцөл, журмын дагуу генетик нөөц, түүнтэй холбоотой уламжлалт мэдлэгийг илрүүлэх, биохайгуул хийх, судлах, ашиглах эрхийг хуулийн этгээдэд олгож болно.

6.4.Энэ хуульд заасан холбогдох зөвшөөрөлгүйгээр генетик нөөц, түүнтэй холбоотой уламжлалт мэдлэгийг илрүүлэх, биохайгуул хийх, судлах, ашиглах, үр шим, ашиг хүртээхийг хориглоно.

7 дугаар зүйл. Генетик нөөц, түүнтэй холбоотой уламжлалт мэдлэгтэй холбогдох үйл ажиллагааг зохицуулах

7.1.Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага /цаашид “төрийн захиргааны төв байгууллага” гэх/ генетик нөөц, түүнтэй холбоотой уламжлалт мэдлэгийн харилцааны талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

7.1.1.генетик нөөц, түүнтэй холбоотой уламжлалт мэдлэгийн талаарх хууль тогтоомжийн хэрэгжилтийг зохион байгуулах;

7.1.2.генетик нөөц, түүнтэй холбоотой уламжлалт мэдлэгтэй холбогдсон аливаа журам, дүрэм, заавар, аргачлал, урьдчилсан мэдэгдэл, талуудын хэлцлийн гэрээ, газарзүйн тодорхойлолт зэрэг холбогдох баримт бичгийн загварыг батлах;

7.1.3.генетик нөөц, түүнтэй холбоотой уламжлалт мэдлэгийг ашиглах эрхийн зөвшөөрөл /цаашид “зөвшөөрөл “гэх/ олгох, сунгах, зөвшөөрлийг хүчингүй болгох;

7.1.4.хуульд өөрөөр заагаагүй бол генетик нөөцийг Монгол Улсын хилээр нэвтрүүлэх зөвшөөрөл олгох, хүчингүй болгох;

7.1.5.энэ хуульд заасан талуудын хэлцлийн гэрээний хэрэгжилтийг хангалтгүй гэж дүгнэвэл гэрээг хүчингүй болгох;

7.1.6.генетик нөөц, түүнтэй холбоотой уламжлалт мэдлэгийг ашиглан гарган авсан бүтээгдэхүүний үнийг судлах, эрэлт, хэрэгцээ, хэтийн төлвийг тодорхойлох, генетик нөөцийн үнэлгээний аргачлал батлах;

7.1.7.генетик нөөцийн тархац, ангилал зүйн судалгаа, генетик нөөцтэй холбоотой уламжлалт мэдлэгийн судалгаа, тооллого зохион байгуулах, генетик нөөцийн үнэлгээг мэргэжлийн байгууллагаар хийлгэх;

7.1.8.зөвшөөрөл эзэмшигчийн генетик нөөц, түүнтэй холбоотой уламжлалт мэдлэгийг хамгаалах, судлах, ашиглахтай холбоотой үйл ажиллагаанд хяналт тавих;

7.1.9.олон нийтэд генетик нөөц, түүнтэй холбоотой уламжлалт мэдлэгийн талаар мэдлэг олгох ажлыг зохион байгуулах, дэмжлэг үзүүлэх, холбогдох хууль тогтоомжийг сурталчлах;

7.1.10.холбогдох олон улсын гэрээний үндэсний зохицуулагчийн үүргийг гүйцэтгэх, мэдээлэл солилцооны тогтолцоотой харьцах;

7.1.11.Энэ хуулийн 7.2-т заасан Мэргэжлийн зөвлөлийн дүгнэлт, зөвлөмжийг хэлэлцэж, холбогдох шийдвэрийг гаргах;

7.1.12. хуульд заасан бусад бүрэн эрх.

7.2.Төрийн захиргааны төв байгууллага генетик нөөц, түүнтэй холбоотой уламжлалт мэдлэгийн асуудал хариуцсан нэгж ажиллуулах ба мэргэжлийн дүгнэлт, зөвлөмж гаргах үүрэг бүхий орон тооны бус Мэргэжлийн зөвлөл /цаашид “Мэргэжлийн зөвлөл” гэх/-тэй байна.

7.3.Байгаль орчны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн Мэргэжлийн зөвлөлийн дүрмийг баталж, бүрэлдэхүүнийг томилж, чөлөөлнө.

7.4.Мэргэжлийн зөвлөлийн бүрэлдэхүүнд тухайн салбарын эрдэмтэн судлаачид, хувийн хэвшил болон төрийн бус байгууллагын төлөөллийг оруулна.

7.5.Мэргэжлийн зөвлөл дараах бүрэн эрхийг эдэлнэ:

7.5.1.генетик нөөц, түүнтэй холбоотой уламжлалт мэдлэгийн талаарх хууль тогтоомжийг боловсронгуй болгох талаар санал, зөвлөмж гаргах, хууль тогтоомжийн хэрэгжилтийн талаар хэлэлцэж дүгнэлт гаргах;

7.5.2.генетик нөөц, түүнтэй холбоотой уламжлалт мэдлэгийн талаарх уламжлалт био-соёлын протокол, ёс зүйн дүрэм боловсруулах;

7.5.3.генетик нөөц, түүнтэй холбоотой уламжлалт мэдлэг ашиглах хүсэлтийг хянаж дүгнэлт, зөвлөмж гаргах;

7.5.4.генетик нөөц, түүнтэй холбоотой уламжлалт мэдлэгийг Монгол Улсын хилээр нэвтрүүлэх асуудлыг хянаж дүгнэлт гаргах;

7.5.5.зөвшөөрөл эзэмшигчийн судалгааны ажлын арга зүй, үр дүнг хянаж дүгнэлт гаргах.

7.6.Аймаг, нийслэлийн байгаль хамгаалах алба нь генетик нөөц, түүнтэй холбоотой уламжлалт мэдлэгийн талаар дараах эрх үүргийг хэрэгжүүлнэ:

7.6.1.генетик нөөц, түүнтэй холбоотой уламжлалт мэдлэгийн талаарх хууль тогтоомж, тэдгээрийг хэрэгжүүлэхтэй холбогдуулан гаргасан шийдвэрийн биелэлтийг өөрийн нутаг дэвсгэртээ зохион байгуулах, хэрэгжилтэд хяналт тавих;

7.6.2.энэ хуулийн 13.2-т заасан цахим бүртгэлийг үндэслэн генетик нөөцийн зүйлийн газарзүйн гарал үүслийн тодорхойлолтыг ажлын 10 хоногийн дотор олгох;

7.6.3.генетик нөөцийг эзэмшигч, ашиглагчийн хооронд байгуулсан талуудын хэлцлийн гэрээний хэрэгжилтэд хяналт тавих;

7.6.4.генетик нөөц, түүнтэй холбоотой уламжлалт мэдлэгийг бүртгэж, энэ хуулийн 8.2-т заасан мэдээллийн нэгдсэн санд мэдээлнэ.

ХОЁРДУГААР БҮЛЭГ

ГЕНЕТИК НӨӨЦ, ТҮҮНТЭЙ ХОЛБООТОЙ УЛАМЖЛАЛТ МЭДЛЭГИЙГ СУДЛАХ, БҮРТГЭХ, ХАДГАЛЖ ХАМГААЛАХ

8дугаар зүйл.Генетик нөөц, түүнтэй холбоотой уламжлалт мэдлэгийн мэдээллийн нэгдсэн сан

8.1.Төрийн захиргааны төв байгууллага генетик нөөц, түүнтэй холбоотой уламжлалт мэдлэгийн бүртгэл, мэдээллийн нэгдсэн сан /цаашид “мэдээллийн нэгдсэн сан” гэх/-тай байна.

8.2.Мэдээллийн нэгдсэн сан нь дараах мэдээллээс бүрдэнэ:

8.2.1.генетик нөөц;

8.2.2.генетик нөөцтэй холбоотой уламжлалт мэдлэг;

8.2.3.генетик нөөц, түүнтэй холбоотой уламжлалт мэдлэгийн цахим бүртгэл.

8.3.Мэдээллийн нэгдсэн сан нь Биологийн олон янз байдлын тухай конвенцийн Генетик нөөц болон тэдгээрийг ашигласнаас үүдэх үр ашгийг шударга, эрх тэгш хуваарилах тухай Нагояагийн протоколын гишүүн орны мэдээлэл солилцооны тогтолцоотой уялдсан байна.

8.4.Энэ хуулийн 8.1-т заасан мэдээллийн нэгдсэн санг бүрдүүлэх, хөтлөх, ашиглах, хадгалах, хамгаалах журам болон мэдээллийн сангийн бүрдэл үзүүлэлтийн жагсаалт, бүртгэлийн маягыг байгаль орчны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

8.5.Иргэн, хуулийн этгээд өөрт хадгалагдаж байгаа генетик нөөцтэй холбоотой ном судар, эрдэм шинжилгээний бүтээл, гар бичмэл, аман мэдээлэл, эдгээртэй адилтгах бусад мэдээллийн цахим хуулбарыг мэдээллийн нэгдсэн санд хадгалуулахаар төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ.

8.6.Энэ хуулийн 12.1-т заасан уламжлалт мэдлэг эзэмшигч уламжлалт мэдлэгээ ашиглуулсны үр шим, ашгийг хүртэхэд энэ хуулийн 8.2.2-т заасан бүртгэлийг үндэслэнэ.

9 дүгээр зүйл.Генетик нөөц, түүнтэй холбоотой уламжлалт мэдлэгийг хадгалж хамгаалах

9.1.Генетик нөөцийг эх байгальд нь амьдрах орчныг хадгалж тэтгэх /in-situ/ замаар болон гаршуулж тэжээх, сэргээн нутагшуулах, тарималжуулах, ботаникийн цэцэрлэг, генийн сан байгуулах /ex-situ/ аргаар хамгаална.

9.2.Төрийн захиргааны төв байгууллага иргэн, хуулийн этгээдэд хадгалагдаж байгаа генетик нөөцтэй холбоотой ном судар, эрдэм шинжилгээний бүтээл, гар бичмэл, бусад уламжлалт мэдлэгийг бүртгэн авч, мэдээллийн нэгдсэн санд хадгална.

9.3.Төрийн захиргааны төв байгууллага энэ хуулийн 9.2-т заасан мэдээллийн нууцлалыг хадгална.

10 дүгээр зүйл.Генийн сан

10.1.Генетик нөөцийг хадгалж хамгаалах зорилгоор төрийн өмчийн эрдэм шинжилгээний байгууллагын дэргэд ургамал, амьтан, бичил биетний төрөлжсөн генийн сан байгуулна.

10.2.Генийн сан байгуулах, генетик нөөцийн сан хөмрөгийг баяжуулж бүртгэх, хадгалж хамгаалах журам, генийн сангийн дүрмийг төрийн захиргааны төв байгууллага батална.

10.3.Генийн сангийн хадгалалтын нэгдсэн стандартыг төрийн захиргааны төв байгууллага боловсруулж, эрх бүхий байгууллагаар батлуулна.

ГУРАВДУГААРБҮЛЭГ

ГЕНЕТИК НӨӨЦ, ТҮҮНТЭЙ ХОЛБООТОЙ УЛАМЖЛАЛТ МЭДЛЭГИЙГ АШИГЛАХ

11 дугаар зүйл.Генетик нөөц, түүнтэй холбоотой уламжлалт мэдлэгийг ашиглахад тавих ерөнхий шаардлага

11.1.Төрийн захиргааны төв байгууллага энэ хуулийн 13 дугаар зүйлд заасан генетик нөөц, түүнтэй холбоотой уламжлалт мэдлэгийг ашиглах эрхийн зөвшөөрлийг Монгол Улсын хуулийн этгээд эсхүл түүнтэй хамтран ажиллах гэрээтэй гадаадын хуулийн этгээдэд олгоно.

11.1.1. Энэ хуулийн 11.1-д заасан хуулийн этгээд нь энэ хуулийн 18 дугаар зүйлд заасны дагуу төрийн захиргааны төв байгууллагад тайлан ирүүлнэ.

11.2.Генетик нөөц, түүнтэй холбоотой уламжлалт мэдлэгийг ашиглах хүсэлт гаргагч /цаашид “хүсэлт гаргагч” гэх/ энэ хуулийн 13.2-т заасан мэдээллийг энэ хуулийн 8.2.3-т заасан мэдээллийн нэгдсэн сангийн цахим бүртгэлд бүртгүүлнэ.

12 дугаар зүйл.Урьдчилсан мэдэгдэл

12.1.Генетик нөөцтэй холбоотой хувийн эзэмшлийн уламжлалт мэдлэгийг ашиглах тохиолдолд хүсэлт гаргагч уламжлалт мэдлэг эзэмшигчээс урьдчилсан мэдэгдэл авна.

12.2.Урьдчилсан мэдэгдэл авахын өмнө тухайн генетик нөөцийн үнэ цэнэ, үр шимийн талаар мэдлэг олгож, генетик нөөцтэй холбоотой тухайн уламжлалт мэдлэг эзэмшигчийг баталгаажуулна.

12.3.Урьдчилсан мэдэгдэл авах журмыг төрийн захиргааны төв байгууллага батална.

12.4.Генетик нөөцтэй холбоотой уламжлалт мэдлэг нь хоёр ба түүнээс олон засаг захиргааны нэгжид оршин суугаа иргэдэд хамаарах тохиолдолд төрийн захиргааны төв байгууллага холбогдох нутгийн захиргааны болон нутгийн удирдлагын байгууллагатай зөвшилцөн баталгаажуулна.

13дугаар зүйл.Тусгай зөвшөөрөл олгох

13.1.Энэ хуулийн 11.1-д заасан шаардлагыг хангасан этгээд генетик нөөц, түүнтэй холбоотой уламжлалт мэдлэгийг судлах, ашиглах эрхийн тусгай зөвшөөрөл хүссэн хүсэлтээ төрийн захиргааны төв байгууллагад гаргана.

13.2.Хүсэлт гаргагч нь дараах материалыг бүрдүүлнэ:

13.2.1.ашиглах генетик нөөцийн нэр болон уламжлалт мэдлэгийн танилцуулга;

13.2.2.хуулийн этгээдийн гэрчилгээний хуулбар;

13.2.3.хуулийн этгээд, түүнтэй хамтран ажиллах гадаадын хуулийн этгээдийн танилцуулга;

13.2.4.хуулийн этгээд ба гадаадын хуулийн этгээдийн хооронд хийсэн гэрээ;

13.2.5.цахим бүртгэлд бүртгүүлсэн баримт;

13.2.6.хувийн эзэмшлийн уламжлалт мэдлэг ашиглах тохиолдолд энэ хуулийн 12.1-д заасан урьдчилсан мэдэгдэл;

13.2.7.газар зүйн гарал үүслийн тодорхойлолт;

13.2.8.генетик нөөц, уламжлалт мэдлэгийг хадгалах, хамгаалах, байгаль орчинд сөрөг нөлөө үзүүлэхээс сэргийлэх арга хэмжээний танилцуулга.

13.3.Төрийн захиргааны төв байгууллага тусгай зөвшөөрлийг хүсэлт хүлээн авснаас хойш ажлын 15 өдөрт багтаан шийдвэрлэнэ.

13.4.Ургамал, амьтны биологийн нөөц бэлтгэх зөвшөөрөлтэй холбоотой харилцааг Байгалийн ургамлын тухай, Амьтны тухай тухай хуулиар зохицуулна.

13.5.Бичил биетний нөөц бэлтгэх, хилээр нэвтрүүлэх журмыг байгаль орчны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

13.6.Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь энэ хуулийн 14.1-д заасан талуудын хэлцлийн гэрээ байгуулсан талаараа мэдээллийн нэгдсэн сангийн цахим бүртгэлд бүртгүүлнэ.

13.7.Судалгааны ажлын үр дүн, тусгай зөвшөөрөл эзэмшигчийн хүсэлтийг үндэслэн тусгай зөвшөөрлийг сунгаж болно.

13.8.Мэргэжлийн зөвлөл зөвшөөрөл эзэмшигчийн талуудын хэлцлийн гэрээний хэрэгжилтийг хангалтгүй гэж дүгнэлт гаргах нь хугацааг сунгахгүй байх үндэслэл болно.

13.9.Тусгай зөвшөөрлийн загварыг байгаль орчны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

13.10.Эрдэм шинжилгээ, судалгааны үр дүнг арилжааны зорилгоор ашиглах тохиолдолд дахин хүсэлт гаргаж тусгай зөвшөөрөл авна.

13.11.Тусгай зөвшөөрлийг бусдад шилжүүлэхийг хориглоно.

13.12.Тусгай зөвшөөрлийг энэ хуулийн 11-13 дугаар зүйлд заасан шаардлагыг зөрчсөн гэж үзвэл зөвшөөрлийг хүчингүй болгоно.

14 дугаар зүйл.Талуудын хэлцлийн гэрээ

14.1.Генетик нөөц, түүнтэй холбоотой уламжлалт мэдлэгийг арилжааны зорилгоор ашиглах тохиолдолд зөвшөөрөл эзэмшигч нь төрийн захиргааны төв байгууллага эсхүл тухайн генетик нөөцтэй холбоотой уламжлалт мэдлэгийг эзэмшигчтэй харилцан тохиролцож, талуудын хэлцлийн гэрээ /цаашид “гэрээ” гэх/ байгуулах бөгөөд түүнд дараах нөхцөлийг тусгана:

14.1.1.гэрээний зорилго, хугацаа;

14.1.2.генетик нөөцийг ашиглах зорилго, зориулалт, ургамал, амьтны шинжлэх ухааны нэр, бичил биетний өсгөврийн дугаар, нэр;

14.1.3.генетик нөөцтэй холбоотой уламжлалт мэдлэгийг ашиглах зорилго, зориулалт, судалгааны үр дүнд бий болох оюуны өмчийн эрхийн талаарх нөхцөл;

14.1.4.генетик нөөц, түүнтэй холбоотой уламжлалт мэдлэгийг ашиглах нөхцөл;

14.1.5.хадгалах, хамгаалах нөхцөл, төлөвлөгөө;

14.1.6.маргаан шийдвэрлэх зохицуулалт;

14.1.7.ашиглалтаас үүдэх үр шим, ашгийг генетик нөөц, түүнтэй холбоотой уламжлалт мэдлэгийг эзэмшигчид хүртээх нөхцөл.

14.2.Ашиглах эрхийн тусгай зөвшөөрөл эзэмшигч нь талуудын хэлцлийн гэрээний хуулбар хувийг төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ.

14.3.Төрийн захиргааны төв байгууллага гэрээний нууцлалыг хадгална.

15 дугаар зүйл.Генетик нөөцийг хилээр нэвтрүүлэх зөвшөөрөл

15.1.Байгалийн ургамал болон амьтан, түүний эд эрхтэнг гадаадад гаргах, гадаадаас оруулах харилцааг Байгалийн ургамлын тухай, Амьтны тухай хуулиар зохицуулна.

15.2.Бичил биетнийг зөвхөн өсгөвөр хэлбэрээр Монгол Улсын хилээр нэвтрүүлэх бөгөөд энэ хуулийн 13.5-т заасан журмын дагуу төрийн захиргааны төв байгууллагаас зөвшөөрөл авна.

15.3.Зөвшөөрөл эзэмшигч нь хилээр нэвтрүүлэх генетик нөөцийн биет эсхүл сорьцын ижил хувийг генийн санд болон бичил биетнийг 2-оос доошгүй өсгөврийн санд хадгалуулсан байна.

16 дугаар зүйл.Генетик нөөц, түүнтэй холбоотой уламжлалт мэдлэгийг ашигласнаас үүдэх үр шим, ашиг

16.1.Генетик нөөц, түүнтэй холбоотой уламжлалт мэдлэгийг ашигласнаас үүдэх үр шим, ашгийг Иргэний хуулийн 88.1-88.3-д заасны дагуу генетик нөөц, түүнтэй холбоотой уламжлалт мэдлэгийг эзэмшигч хүртэнэ.

16.2.Генетик нөөц, түүнтэй холбоотой уламжлалт мэдлэгийг ашигласнаас үүдэх үр шим, ашиг мөнгөн ба мөнгөн бус хэлбэртэй байна.

16.3.Генетик нөөц, түүнтэй холбоотой уламжлалт мэдлэгийг ашигласнаас үүдэх мөнгөн үр шим, ашиг нь судалгаа, боловсруулалтын үр дүнд бий болсон бүтээгдэхүүний борлуулалтын орлого, тусгай зөвшөөрлийн хураамж, оюуны өмчийн эрхийн хамтын эзэмшил болон бусад хэлбэртэй байж болно.

16.4.Генетик нөөц, түүнтэй холбоотой уламжлалт мэдлэгийг ашигласнаас үүдэх мөнгөн бус үр шим, ашиг нь дараах хэлбэртэй байж болно:

16.4.1.хамтарсан судалгаа;

16.4.2.хамтран бүтээгдэхүүн хөгжүүлэлт;

16.4.3.чадавх бэхжүүлэх сургалт;

16.4.4.технологи дамжуулалт;

16.5.Гэрээ байгуулагч талууд харилцан тохиролцож энэ хуулийн 16.1-д заасныг баримтлан энэ хуулийн 14.1-д заасан гэрээний нөхцөлд генетик нөөц, түүнтэй холбоотой уламжлалт мэдлэгийг ашигласнаас үүдэх үр шим, ашгийг хүртээх мөнгөн эсхүл мөнгөн бус хэлбэрийг тусгана.

17 дугаар зүйл. Генетик нөөц, түүнтэй холбоотой уламжлалт мэдлэг ашигласны төлбөр

17.1.Амьтан, ургамал, биологийн нөөц ашигласны төлбөрийг Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулиар зохицуулна.

17.2.Энэ хуулийн 7.6.2, 12, 13-р зүйлд заасан гарал үүслийн тодорхойлолт, урьдчилсан мэдэгдэл, тусгай зөвшөөрлийн төлбөр, хураамжийн хэмжээ болон бусад судалгаа шинжилгээ явуулах холбогдох зөвшөөрлийг Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулиар зохицуулна.

17.3.Тусгай зөвшөөрөл эзэмшигч генетик нөөц ашиглан гаргаж авсан бүтээгдэхүүний борлуулалтын орлогоосоо генетик нөөц эзэмшигчид дараах байдлаар мөнгөн эсхүл мөнгөн бус үр шим, ашгийг хүртээнэ:

17.3.1.Мөнгөн үр шим, ашиг нь бүтээгдэхүүний борлуулалтын орлогын үнийн дүнгийн 2-оос доошгүй хувь байна.

17.3.2.Мөнгөн бус үр ашиг нь бүтээгдэхүүний борлуулалтын орлогын үнийн дүнгийн 1.5-аас доошгүй хувь байна.

17.4.Эзэмшигчийг нь тогтоох боломжгүй буюу төрийн мэдлийн генетик нөөцтэй холбоотой уламжлалт мэдлэгийг ашиглан гаргаж авсан бүтээгдэхүүний борлуулалтын орлогын үнийн дүнгийн 2-оос доошгүй хувийг тусгай зөвшөөрөл эзэмшигч генетик нөөцтэй холбоотой уламжлалт мэдлэг ашигласны төлбөрт төлнө.

17.5.Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь хувийн эзэмшлийн генетик нөөцтэй холбоотой уламжлалт мэдлэгийг ашиглан гаргаж авсан бүтээгдэхүүний борлуулалтын орлогоос дараах байдлаар төлбөр төлнө:

17.5.1.бүтээгдэхүүний борлуулалтын үнэлгээний 0,5 хувьтай тэнцэх төлбөрийг улсын төсөвт төлнө.

17.5.2.генетик нөөцтэй холбоотой уламжлалт мэдлэг эзэмшигчид хүртээх мөнгөн эсхүл мөнгөн бус үр шим, ашгийн хэлбэр, төлбөрийн хэмжээг талуудын хэлцлийн гэрээнд нэмж тусгана.

17.6.Генетик нөөц, түүнтэй холбоотой уламжлалт мэдлэгт үндэслэсэн генетик нөөц ашигласны үр шим, ашгийн төлбөрийн орлогын 50-аас доошгүй хувийг Байгаль орчин, уур амьсгалын санд төвлөрүүлэн, генетик нөөцийг тогтоох, судлах, хамгаалах, нөхөн сэргээх, мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлэхэд зарцуулна.

17.7.Генетик нөөц нь хязгаарлагдмал хүрээний тодорхой нутаг дэвсгэрээс гарал үүсэлтэй тохиолдолд түүнээс үүдэх үр шим, ашгийн 35-аас доошгүй хувийг тухайн нутаг дэвсгэрийн генетик нөөцийг хамгаалах, орон нутгийг хөгжүүлэхэд зарцуулна.

17.8.Генетик нөөц, түүнтэй холбоотой уламжлалт мэдлэг ашиглаж гаргасан бүтээгдэхүүний борлуулалтын үнэлгээг дараах байдлаар тооцно:

17.8.1.экспортод бүтээгдэхүүн гаргасан бол олон улсын худалдаанд хүлээн зөвшөөрөгдсөн тухайн жилийн дундажийг тогтоох зарчмыг үндэслэн тухайн бүтээгдэхүүний, эсхүл түүнтэй адил төстэй бүтээгдэхүүний олон улсын зах зээлийн үнийг үндэслэн;

17.8.2.дотоодод ашигласан, борлуулсан бол тухайн бүтээгдэхүүний эсхүл түүнтэй адил төстэй бүтээгдэхүүний дотоодын зах зээлийн үнийг үндэслэн;

17.8.3.дотоодын болон олон улсын зах зээлд борлуулсан бүтээгдэхүүний зах зээлийн жишиг үнийг тодорхойлох боломжгүй тохиолдолд зөвшөөрөл эзэмшигчийн мэдүүлсэн борлуулалтын орлогыг үндэслэнэ.

17.9.Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь генетик нөөц, түүнтэй холбоотой уламжлалт мэдлэгийг ашгийн бус судалгаа шинжилгээний зорилгоор ашиглах тохиолдолд мөнгөн хэлбэрээр үр шим, ашиг хүртээхгүй байж болно.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ

БУСАД ЗҮЙЛ

18 дугаар зүйл. Мэдээ, тайлан гаргах

18.1.Зөвшөөрөл эзэмшигч нь дараах мэдээ, тайланг дор дурдсан хугацаанд гаргаж, төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ:

18.1.1.генетик нөөц, түүнтэй холбоотой уламжлалт мэдлэгийг ашиглаж байгаа талаарх ажлын жилийн тайланг жил бүрийн 12 дугаар сард;

18.1.2.мэдээллийн нэгдсэн санд орох мэдээллийг тухай бүр;

18.1.3.генетик нөөц, түүнтэй холбоотой уламжлалт мэдлэгийг дотооддоо ашиглах бол зардлын төсвийн гүйцэтгэлийг жил бүр, гадаадад ашиглах бол холбогдох явцын тайланг жил бүрийн 12 дугаар сард;

18.2.Зөвшөөрөл эзэмшигч нь тухайн жилд борлуулсан генетик нөөцөөс гаралтай бүтээгдэхүүний тоо хэмжээ, улсын төсөвт төлсөн төлбөрийн хэмжээг дараа оны 1 дүгээр улиралд багтаан төрийн захиргааны төв байгууллагад мэдээлнэ.

19 дугаар зүйл.Хууль тогтоомж зөрчигчид хүлээлгэх хариуцлага

19.1.Генетик нөөцийн тухай хууль тогтоомж зөрчсөн нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол Зөрчлийн тухай хууль болон Төрийн албаны тухай хуулийн дагуу хариуцлага хүлээлгэнэ.

20 дугаар зүйл. Хууль хүчин төгөлдөр болох

20.1.Энэ хуулийг 2018 оны ... дугаар сарын.... ны өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

Санал өгөхөд холбогдох утас, и-майл хаяг:

утас:11-311127

odjargal@mne.gov.mn,

odjargal@gmail.com,